



АРХАНГАЙ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 62

Цэцэрлэг

Тээврийн хэрэгсэл тусгай хашаа /талбай/-нд түр
байлгах хугацааны төлбөр хураамж шинэчлэн
тогтоох тухай

“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Хууль зүйн сайдын 2015 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/30 дугаар тушаалыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн Тээврийн хэрэгсэл тусгай хашаа /талбай/-нд түр байлгах хугацааны төлбөр хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Тээврийн хэрэгсэл тусгай хашаа /талбай/-нд түр байлгах хугацааны төлбөр хураамжийг тогтоосон журмын дагуу улсын орлогод төвлөрүүлж, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар /Я.Ганбат/-т үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.МӨНХБАТ

О. Чинзориг

Тогтоомыг даргын үүрэг
оринголт болгох

байгуулалт дунд
татгалзвал.

О. Чинзориг 2/26

Аймгийн ИТХ-ын өргүүлэгчдийн 2015 оны
09 дүгээр сарын 17 ний өдрийн 62
дугаар тогтоолын хэвсрэлт

**ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ТУСГАЙ ХАШАА /ТАЛБАЙ/-НД ТҮР
БАЙЛГАХ ХУГАЦААНЫ ТӨЛБӨР**

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Хоногийн хураамж	Тээврийн хэрэгсэл тусгай хашаа /талбай/-нд байлгах хугацааны төлбөрийн дээд хэмжээг 30 хоногоор тооцож авна.
1	Мотоцикл	2500	
2	Бүх төрлийн суудлын автомашин	4000	
3	Бүх жин 3500 кг хүртэл ачааны авто машин бүх төрлийн жийп	5000	
4	Бүх жин 3500 ба түүнээс дээш 10000 кг хүртэлх ачааны автомашин	7000	
5	Бүх жин 10000 кг ба түүнээс дээш ачааны авто машин	10000	
6	Механизм	7000	
7	Микро автобус /20 хүртэл хүний суудалтай/	6000	
8	Том оврын автобус /20 ба түүнээс дээш хүний суудалтай/	8000	
9	Бүх төрлийн ачааны автомашины чиргүүл	4000	



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2015 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 6/96

Цэцэрлэг

Зардлын хэмжээ тогтоох тухай

Хууль зүйн сайдын 2014 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/133 дугаар тушаал, Цагдаагийн газрын даргын 2015 оны 09 дүгээр сарын 19 дүгээр хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн баривчлах байранд байсан хугацааны шууд зардлын хэмжээг 6100 төгрөгөөр /зургаан мянга нэг зуу/ төгрөгөөр шинэчлэн тогтоон баталсугай.



Хоёр. Энэ тушаалыг 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

Гурав. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж хэрэгжүүлж ажиллахыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Г. Пүрэвдорж/, Ахлах нягтлан бодогч, /цагдаагийн ахмад Д. Мөнхцагаан/ нарт үүрэг болгосугай.

Дөрөв. Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд танилцуул.

ДАРГА, ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Я. ГАНБАТ



0000470